

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.060.20

Унд, ахуйн зориулалттай усны төвлөрсөн хангамжийн эх булгийг сонгох журам ба эрүүл ахуйн шаардлага Источники централизованного хозяйственно- питьевого водоснабжения. Гигиенические требования и правила выбора	MNS 0899:92
Sources of centralized drinking Water Supply , Sanitary requirements and rules of Selection	MNS 0899 - 1967-ийн оронд

Монгол улсын үндэсний стандартчилал, хэмжилзүйн төвийн тэргүүлэгчдийн 1992 оны 15 дугаар тогтоолын дагуу 1993 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөнө.

Энэхүү стандартын шаардлагыг заавал мөрдөнө

Энэ стандарт нь түгээгүүрийн сүлжээгээр дамжуулан унд, ахуй, техникийн хэрэгцээнд хослон ашиглах төвлөрсөн усан хангамжийн системийн эх булгийг хүн амын эрүүл мэндийг хамгаалах эрх ашигт нийцүүлж сонгон авах эрүүл ахуйн шаардлагыг тогтооход хамаарна.

Төвлөрсөн бус усан хангамжийн эх булаг болон рашаан усны эх булаг сонгон авахад энэ стандарт хамаарахгүй.

1 Ерөнхий шаардлага

1.1 Түгээгүүрийн сүлжээгээр дамжин хэрэглэгчдэд очих ус нь чанарын үзүүлэлтүүдээр улсын стандарт (УСТ 900-92)-д заасан шаардлага хангаж, эрүүл ахуй, халдвар судлалын хувьд найдвартай хамгаалагдсан уст цэгүүдийг төвлөрсөн усан хангамжийн эх булагт сонговол зохино.

1.2 Тухайн усны эх булаг нь хүн амын унд, ахуйн хэрэгцээнд тохирох эсэхийг дараах нөхцөлийг үндэслэн тогтооно. Үүнд:

- эх булагт газрын доорхи усыг сонгосон нөхцөлд ус авах байгууламжууд байрлах орчны эрүүл ахуй халдвар судлалын дүгнэлт
- гадаргын усыг сонгосон нөхцөлд ус авах газар түүнээс дээш, доош орших хэсгийн эрүүл ахуй, халдвар судлалын дүгнэлт
- эх булгийн усны чанар, найрлага
- усны ундарга, урсацын хэмжээ, нөөц, ус ашиглалтын хэтийн төлөвийн талаар мэргэжлийн байгууллагаас гаргасан дүгнэлт, тооцоо
- эх булаг байрлаж байгаа газар орны ус, газар зүй, байршил зүйн зураг болон холбогдох материалуудыг судалдаг мэдээллийн байгуул-лагуудын дүгнэлт, тус тус хамаарна.

1.3. Усан хангамжийн системийн зураг төслийн гүйцэтгэгч байгууллага нь уст цэгүүд байрлаж байгаа газрын орчны эрүүл ахуй, халдвар судлалын үр дүн, ус газар зүйн байршил зүйн зураг зэрэг холбогдох материалуудыг мэргэжлийн байгууллагуудар судлуулж, усны эх булгийн одоогийн болон хэтийн төлөвт үнэлгээ дүгнэлт гаргуулах ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

1.4 Уст цэгүүд ундны усан хангамжийн системд тохирох эсэх талаар Ундны ус, эрүүл ахуйн шаардлага түүнд тавих хяналт УСТ 900-92-д заасан усны чанарын бүх үзүүлэлтүүдийг зохих стандартын дагуу тодорхойлсон лабораторийн

MNS 0899:92

шинжилгээний дүнг үндэслэн Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын байгууллага дүгнэлт гаргах ёстой.

2 Эрүүл ахуй, техникийн шаардлага

2.1 Унд ахуйн төвлөрсөн усан хангамжийн зориулалттай газрын доорх болон гадаргын эх булгийн усны мэдрэгдэх чанарт нөлөөлөх химийн зарим бодисуудын агууламж Ундны ус эрүүл, ахуйн шаардлага түүнд тавих хяналт УСТ 900-92-ын 2.6.6.-д заасан хэмжээнээс хэтэрч болохгүй.

2.2 Унд ахуйн зориулалтаар ашиглагдах ус нь мэргэжлийн байгууллагаас баталсан цацрагийн аюулгүйн хэм хэмжээг хангасан байх ёстой.

2.3 Унд ахуйн хэрэгцээний төвлөрсөн усан хангамжийн эх булгийн усны чанарыг сайжруулахтай уялдуулж физик химийн шинж чанарын үзүүлэлтээр нь 1, 2, 3, гэсэн зэргээр ангилах бөгөөд зэрэг тус бүрт зөвшөөрөгдөх үзүүлэлтийн хэмжээ 1, 2-р хүснэгтэнд зааснаас хэтэрч болохгүй. 1-р хүснэгт

Газрын доорхи ус

Д/д	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Усны чанарын зэрэг		
			I	II	III
1	Булингаршил	мг/дм ³	1,5	1,5	1,5
2	Өнгө	градус	20	20	50
3	Манган	мг/дм ³	0,1	1,0	2,0
4	Хүхэрт устөрөгч	мг/дм ³	-	3,0	10,0
5	Төмөр	мг/дм ³	0,3	10,0	20,0
6	Устөрөгчийн илтгэгч				
7	Фтор	РН	6,5-8,5	6,5-1,5	6,5-8,5
8	1 дм ³ усан дахь гэдэсний бүлгийн савханцарын тоо	мг/дм ³	0,7-1,5	0,7-1,5	5,0
			3	100	1000

2-р хүснэгт**Гадаргын ус**

Д/д	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Усны чанарын зэрэг		
			I	II	III
1	Булингаршил	мг/дм ³	20	1500	10000
2	Өнгө	градус	35	120	200
3	Үнэр (20 ⁰ С ба 60 ⁰ С-т)	оноо	2	3	4
4	Исэлдэх чанар	мгО ₂ /дм ³	7	15	20
5	Манган	мг/дм ³	0,1	1,0	2,0
6	Хүчилтөрөгчийн биохимийн хэрэгцээ (ХБХ)	мгО ₂ /дм ³	3	5	7
7	Төмөр	мг/дм ³	1,0	3,0	5,0
8	Устөрөгчийн илтгэгч	РН	6,5-8,5	6,5-8,5	6,5-8,5
9	Фитопланктон	мг/дм ³	1,0	5,0	50,0
10	1 дм ³ усан дахь лактозот эерэг гэдэсний савханцарын тоо		1000	10000	50000

Тайлар: Фитопланктоны хэмжээг 2 янзаар тодорхойлно.

а/ 1 дм³ усанд агуулагдаж байгаа хавтгай ба утаслаг биетийг, мг-аар

б/ 1 см³ усанд агуулагдах нэг эст биетийг, тоогоор э.т.

2. Усны физик химийн үзүүлэлтүүдийг зохих стандартуудын шаардлагын дагуу тодорхойлно.

2.4 Төвлөрсөн усан хангамжийн эх булгийн усны чанарын зэргийг харгалзан усны чанарыг сайжруулах байгууламжийн зураг, төсөл боловсруулж технологийн горимыг тогтоохдоо түүний үйл ажиллагааны үе шат бүрт лабораторийн шинжилгээ, туршилтын ажил гүйцэтгэж үр дүнг нь үндэслэн энэ стандартын "А" хавсралтанд заасан усны чанарын үзүүлэлтийг сайжруулах арга хэмжээг зохих шаардлагад хүргэж хэрэгжүүлэх ёстой.

2.5 Эх булгийн усыг сайжруулах арга технологийн горимын найдвартай ажиллагааг холбогдох мэргэжлийн байгуулагууд туршин баталгаажуулж, эрүүл ахуйн талаас мэргэжлийн хяналтын байгууллага шинжилж, зөвшөөрөл олгосон нөхцөлд тухайн эх булгийг усан хангамжийн төвлөрсөн системд ашигладаг журмыг мөрдлөг болгоно.

2.6 Усан хангамжийн эх булаг, ус дамжуулах барилга байгууламжид улсын усны болон эрүүлийг хамгаалах хууль тогтоомжийн дагуу хамгаалалтын бүс тогтоож, усны нөөцийг бохирдол, хордлогоос найдвартай хамгаалсан байна.

3 Усны эх булгийг сонгох, усны чанарыг үнэлэх

3.1 Унд ахуйн хэрэгцээний зориулалттай усан хангамжийн системийн эх булагт бохирдлоос найдвартай хамгаалсан нөхцөлд байгаа газрын доорхи давхарга хоорондын түрэлттэй усыг сонгон авна. Хэрэв ийм нөхцөл байхгүй тохиолдолд шаардлага хангасан ус бүхий дараах эх булгийг сонгоно. Үүнд:

- газрын доорхи давхарга хоорондын түрэлтгүй ус
- газрын доорх ан цав болон хөрсний ус (ул хөрснөөс болон зохиомлоор нөөц нь сэргээгддэг)
- гадаргын ус, гол мөрөн, нуур булаг, шанд, усан сан гэх мэт

3.2 Төвлөрсөн усан хангамжийн системд ашиглах усны нөөц нь хэд хэдэн уст цэгээс бүрдэж байвал тэдгээрээс олдворлох усны нийт хэмжээ тухайн усыг хэрэглэгч хүн амын усны хоногийн хэрэгцээний дээд хэмжээ, түүний хэтийн төлөвөөр өргөжин нэмэгдэх усны хэрэгцээг хангаж чадахаар байвал зохино.

3.3 Усан хангамжинд ашиглах зорилгоор уст цэгүүдээс зөвхөн хамгаалалтын бүс тогтоож, ус сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх бодит бололцоотойг нь эх булагт сонгон авах ёстой.

3.4 Усан хангамжийн системд ашиглах эх булагт газрын доорхи усыг ашиглах тохиолдолд "Б" хавсралтанд, гадаргын усыг ашиглах тохиолдолд "В" хавсралтанд заасан үзүүлэлтээр тус тус шинжилсэн дүнг үндэслэн тухайн усны чанарын үзүүлэлтийг үнэлж тогтооно.

3.5 Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын байгууллага нь сонгож авсан эх булгийн талаар холбогдох мэргэжлийн байгууллагуудаас гаргасан дүгнэлт

MNS 0899:92

материалуудыг "Г" хавсралтанд заасан хөтөлбөрийн дагуу судалсны үндсэн дээр уг эх булгийг унд ахуйн төвлөрсөн усан хангамжийн системд тохирох эсэхийг тодорхойлж, эрүүл ахуйн дүгнэлт гаргах ёстой.

3.6 Төвлөрсөн усан хангамжийн системд сонгон авсан эх булаг унд ахуйн хэрэгцээнд тохирох эсэх тухай Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын байгууллагаас гаргасан дүгнэлт 3 жилийн хугацаанд хүчинтэй байна. Хугацаа дуусмагц усан хангамжийн системийг эзэмшигч байгууллага нь Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын байгууллагаас эх булгийн усны чанарын талаар эрүүл ахуйн дүгнэлтийг давтаж гаргуулж баталгаажуулах ёстой.

3.7 Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын байгууллага нь төвлөрсөн усан хангамжийн системээс эх булгийн усны чанарыг Ундны ус, эрүүл ахуйн шаардлага түүнд тавигдах хяналт УСТ 900-92-ын 3.5-д заасны дагуу сүүлийн 3-аас доошгүй жилийн туршид хянаж шинжилсэн дүнг үндэслэн уг эх булгийн усны чанарыг үнэлж баталгаа гаргавал зохино.

ТӨГСӨВ

А.Хавсралт (Заавал мөрдөнө)

Усны чанарын зэрэг, ус сайжруулах арга

Эх булгийн усны чанарын зэрэг	Ундны ус, Эрүүл ахуйн шаардлага түүнд тавих хяналт УСТ 900-92-ын шаардлага хангасан байдал	Ус сайжруулахад шаардагдах аргууд
I	1. Газрын доорхи ус Усны чанарын бүх үзүүлэлтээр стандартын шаардлага хангасан байдал	Ус сайжруулах арга шаардагдахгүй
II	а/ усны чанар зарим үзүүлэлтээр стандартын шаардлага хангаагүй байна. б/ усны чанар нь улирлын байдлаас хамааран хэлбэлздэг, тухайлбал хуурай үлдэгдлийн хэмжээ стандартад зааснаас ихсэх гэх мэт	-агааржуулах - шүүх -халдваргүйжүүлэх - урьдчилан сэргийлэх - халдваргүйжүүлэх
III	Усны чанар бичил амь, хор судлал, мэдрэгдэх зарим үзүүлэлтээр стандартын шаардлага хангаагүй байна.	- агааржуулах - тунгаах - шүүх - халдваргүйжүүлэх - химийн аргаар урвалж ашиглан цэвэршүүлэх
I	2. Гадаргын ус а/ усны чанар бүх үзүүлэлтээр стандартын шаардлага хангасан байна.	Ус сайжруулах арга шаардлагагүй
	Усны чанар зарим үзүүлэлтээр стандартын шаардлага хангаагүй байна.	- тундасжуулах - шүүх - халдваргүйжүүлэх
II	Усны чанар нилээд үзүүлэлтээр стандартын шаардлага хангаагүй байна	- тундасжуулах - тунгаах - шүүх - халдваргүйжүүлэх - фитопланктоны нарийн шүүүүр ашиглах

III	Усны чанар стандартын шаардлага хангаагүй боловч усыг сайжруулах боломжтой	II зэрэгт хамаарах ус сайжруулах аргуудаас гадна - исэлдүүлэх химийн аргаар тундасжуулах - тодорхой химийн урвалж ашиглан халдваргүйтгэлийн үр дүнг нэмэгдүүлэх
-----	--	---

Б хавсралт (Зөвлөмж)

Газрын доорх усны чанарыг шинжилсэн тухай протокол

1. Усан хангамжийн эх булгийн нэр, улсын дугаар
2. Дээж авсан уст цэгийн орших газрын хаяг
3. Уст давхаргын гүн, усны хөдөлгөөнт ба тогтонги түвшин м-ээр
4. Дээж авсан хүний овог нэр, албан тушаал, ажлын хаяг.....
5. Дээж авсан арга
6. Дээж авсанонсарөдөрцагмин
7. Дээжийг лабораторид авчирсанонсарөдөрцагмин
8. Шинжилгээг эхэлсэнонсарөдөрцагмин Дууссан.....онсарөдөрцагмин
9. Шинжилгээг хийсэн лабораторийн нэр, хаяг утасны дугаар

**Усны чанарын үзүүлэлт
А.Мэдрэгдэх үзүүлэлтүүд**

1. Мэдрэхүйн аргаар тодорхойлох үзүүлэлт:

1. Дээж авах үеийн усны температур, үзүүлэлтүүд
2. Амт, цельсийн 20 хэмд оноогоор
3. Булингаршил мг/дм³-ээр
4. Өнгө, градусаар
5. Үнэр а/ цельсийн 20 хэмд оноогоор
б/ цельсийн 60 хэмд оноогоор

2. Химийн үзүүлэлт

- | | |
|---|-----------------------------------|
| 1. Зэс (Cu ²) | мг/дм ³ |
| 1. 2. Кальцийн ион (Ca ²) | мг/дм ³ |
| 3. Исэлдэх чанар (пергаманганатын) | мгО ₂ /дм ³ |
| 4. Магнийн ион (Mg ²) | мг/дм ³ |
| 5. Манган (Mn ²) | мг/дм ³ |
| 6. Нүүрсхүчлийн хий (CO ₂) чөлөөт байдлаар | мг/дм ³ |
| 7. Сульфат (SO ₄ ²) | мг/дм ³ |
| 8. Төмрийн нийт хэмжээ (Fe ² , Fe ³) | мг/дм ³ |
| 9. Устөрөгчийн илтгэгч | РН |
| 10. Фенолын нэгдлүүд | мг/дм ³ |
| 11. Фосфатын ион (PO ₄ ³) | мг/дм ³ |

- | | |
|-----------------------------|------------------------|
| 12. Хатуулагийн нийт хэмжээ | мг экв/дм ³ |
| 13. Хлорид (Сl) | мг/дм ³ |
| 14. Хуурай үлдэгдэл | мг/дм ³ |
| 15. Цайр (Zn ²) | мг/дм ³ |

Б.Хор судлалын үзүүлэлт хэмжих нэгж мг/дм³

1. Анзан (Mo)
2. Биндэр (Be)
3. Зөөлөн цагаан (Cd)
4. Мөнгө (Ag)
5. Нитрат (NO₃)
6. Поликриламидын үлдэгдэл хэмжээ
7. Селен (Se)
8. Стронци (Sr)
9. Хар тугалга (Pb)
- 10.Хромын нийт хэмжээ (Cr)
- 11.Хөнгөн цагааны үлдэгдэл хэмжээ
- 12.Хүнцэл (As)
- 13.Хүхэрт устөрөгч (H₂S)
- 14.Цианид (CN)
- 15.Фтор (F)

В.Үйлдвэр хөдөө аж ахуйн гаралтай химийн бохирдлыг тодорхойлох нэмэлт үзүүлэлт

1.
2.
3.
4.
5.

Г.Бичил амь судлалын үзүүлэлт

1. 1 см³ шингэлээгүй усан дахь нийт нянгийн тоо
2. 1 дм³ усан дахь гэдэсний бүлгийн савханцарын тоо

Д. Усны чанарын II, III зэрэгт хамаарах усанд тодорхойлох нэмэлт үзүүлэлт

1. 1 дм³ усан дахь гэдэсний халдвар үүсгэгчид:
 - сальмонелууд
 - энтеровирусууд
2. 1 дм³ усан дахь E.Coli-ын тоо
3. 1 дм³ усан дахь колифагийн тоо
4. 1 дм³ усан дахь энтерококкийн тоо
5. Аммоны давс (NH₂) мг/дм³
6. Нитрит (NO₂) мг/дм³

Шинжилгээг хийсэн :

ХимичОВОГОЙ.....

Нян судлаачОВОГОЙ.....

"Б" хавсралтын үргэлжлэл

Эрүүл ахуйн дүгнэлт

.....онсар.....өдөр

Дүгнэлт бичсэн.....Эрүүл ахуйн
(улс аймаг, хотын)
байцаагчОВОГТОЙ.....

”В” хавсралт (Зөвлөмж)

Гадаргын усны чанарыг шинжилсэн тухай протокол

1. Усан хангамжийн эх булгийн нэр, улсын дугаар.....
2. Дээж авсан газрын нэр
3. Дээж авсан хүний овог нэр, албан тушаал, ажлын хаяг
.....
4. Дээж авсан арга
5. Дээжийг авсанон.....сар.....өдөр.....цаг мин
6. Лабораторид авчирсанон.....сар.....өдөр.....
цаг.....мин
7. Шинжилгээг эхэлсэнон.....сар.....өдөр.....
цаг.....мин
8. Шинжилгээг хийсэн лабораторийн нэр, хаяг, утасны дугаар.....
.....

Усны чанарын үзүүлэлт

А.Мэдрэхүйн үзүүлэлт

- | | |
|------------------------------------|--|
| 1. Дээж авах үеийн усны температур | цельсийн хэм |
| 2. Амт, цельсийн 20 градуст | оноогоор |
| 3. Булингаршил | мг/дм ³ |
| 4. Өнгө | градусаар |
| 5. Үнэр | а/ цельсийн 20 хэм
б/ цельсийн 60 хэм |
| | оноогоор
оноогоор |

2. Химийн үзүүлэлт

- | | |
|---|------------------------|
| 1. Жигнэгдэгч бодисын хэмжээ | мг/дм ³ |
| 2. Манган (Mn) | мг/дм ³ |
| 3. Нүүрсхүчлийн хий (CO ₂) чөлөөт байдлаар | мг/дм ³ |
| 4. Сульфат (SO ₄ ²⁻) | мг/дм ³ |
| 5. Төмрийн нийт хэмжээ (Fe ²⁺ , Fe ³⁺) | мг/дм ³ |
| 6. Устөрөгчийн илтгэгч (PH) | |
| 7. Фтор (F) | мг/дм ³ |
| 8. Хуурай үлдэгдэл | мг/дм ³ |
| 9. Хлорид | мг/дм ³ |
| 10.Шүлтлэг | мг экв/дм ³ |

**Б.Үйлдвэр аж ахуйн гаралтай цацраг, химийн
бохирдлыг тодорхойлох нэмэлт үзүүлэлт**

1.
2.
3.
4.

5.

В.Шим бохирдлыг тодорхойлох химийн үзүүлэлт

- | | |
|---|-----------------------------------|
| 1. Гадаргын ба анионы идэвхт бодисын нийлбэр хэмжээ | мг/дм ³ |
| 2. Хүчилтөрөгчийн биохимийн хэрэгцээ (ХБХ) бүрэн | мгО ₂ /дм ³ |
| 3. Исэлдэх чанар (пергаманганатын) | мгО ₂ /дм ³ |
| 4. Аммоны давс | мг/дм ³ |
| 5. Нитрат | мг/дм ³ |
| 6. Нитрит | мг/дм ³ |

Г.Бичил амь судлалын үзүүлэлт

1. 1 см³ шингэлээгүй усан дахь нийт нянгийн тоо
2. 1 см³ усан дахь лактоз эерэг гэдэсний савханцарын тоо
3. 1 дм³ усан дахь гэдэсний халдвар үүсгэгчид:
 - сальмонеллууд
 - шигелл
 - энтеровирусууд
4. 1 дм³ усан дахь колифагийн тоо
5. 1 дм³ усан дахь энтерококкийн тоо
6. Фитопланктоны хэмжээ мг/дм³-ээр
7. Фитопланктоны тоо э.т/см³

Шинжилгээг хийсэн :

Химич:.....овогтой

Нян судлаач.....овогтой.....

Эрүүл ахуйн дүгнэлт

.....он.....сар.....өдөр

.....

Дүгнэлт бичсэн:.....(улс, аймаг, хотын) эрүүл ахуйн
байцаагч..... овогтой.....

Усан хангамжийн эх булгийг судлах хөтөлбөр

1. Газрын доорх ус

1.1 Тухайн орон нутгийн газар зүйн бутцийн онцлог, цооног, өрөмдсөн гүний хөрсний бүтэц, уст давхаргын ус, газарзүйн тогтоц (элс хайрга, ан цавт чулуулаг гэх мэт) ашиглах буюу ашиглаж байгаа уст үеүд, цооног дахь усны гүн, хөдөлгөөнт ба тогтонги түвшин, ундрага.

1.2 Усан хангамжид ашиглах усны савын тэжээгдэх нөхцөл, хөрс, орчны эрүүл ахуйн байдал, уст үеийн ус өгөх нөхцөл, чадал, авах усны тооцоолсон хэмжээгээр усны хөдөлгөөнт түвшингийн өөрчлөгдөх байдал, буурцын хүнхийн хязгаар.

1.3. Уст үеийг хучигч хөрсний ус нэвчүүлэх чанар, усаар тэжээгдэх бүсийн нөхцөл байдал усны чанарт нөлөөлөх эсэх тухай судалгааны дүн.

1.4 Уст цэгүүд байрлаж байгаа орчны эрүүл ахуйн байдал, бохирдуулах эх үүсвэрээс худаг хүртэлх зай, ашиглагдахгүй болсон худаг байгаа эсэх, хамгаалалтын бүс тогтоолт, түүний хязгаарууд усны чанарыг сайжруулах нэмэлт арга хэмээ шаардлагатай эсэх тухай.

2. Гадаргын ус

2.1 Ус зүй, ус хэмжүүрийн үзүүлэлтүүд (ус авах газрын тэжээгдэх талбайн хэмжээ) гадаргын урсацын горим, улирлын хэлбэлзэл, ус авах цэг дэх усны түвшин, урсгалын хурд дундаж хамгийн их, бага зарцуулалт, хөлдөх, гэсэх дундаж хугацаа, тухайн эх булгаас авч ашиглах усны хэмжээ, эх булгийн хамгийн бага зарцуулалт нь энэ хэрэгцээг хангаж чадах эсэх.

2.2 Усны сав газрын ус авах цэг дэх усны чанарт нөлөөлж болох дараах байдлууд:

- сав газрын хөрс, ургамал, ой, газар зүйн бүтэц шинж байдал, төв суурингийн газар эдэлбэрийн байдал, байршил
- оршин суугч хүн амын эрхэлдэг үйлдвэр, хөдөө аж ахуйн салбар, тэдгээрийн байршил, үйлдвэрлэлийн онцлог
- усан сангийн усны чанарт муугаар нөлөөлж болох хүчин зүйлс, үйлдвэр хөдөө аж ахуйн салбар, тэдгээрээс гарах хаягдлын цэвэрлэх байгууламж, бохир ус оруулах цэгээс ус авах газар хүртэлх зай, усыг тээвэр, спорт, сал урсгах, мал усалгаанд ашигладаг эсэх, усны гольдролд хаясан хог зэрэг бохирдлын эх үүсвэр байгаа эсэх.

2.3 Усан сангийн өөрөө цэвэрших чанар, хамгаалалтын бүс тогтоолт, түүний хязгаарууд

2.4 Хиймэл усан санг түүний эх булагт сонгосон тохиолдолд дээр дурдсан эрүүл ахуйн байдлаас гадна усан сангийн ерөнхий ба ашигт эзлэхүүн, тэжээгдэх нөхцөл, ус хураамжлалт, усны гүний хамгийн их, бага хэмжээ, эрэг далан ёроолын байдал (ургамалжилт, хурдас шаварлиг үүсэлт) усны урсгал, салхины ноёлох чиглэл зэргийг нэмж судална.

2.5 Гадаргын усны чанарыг сайжруулах арга хэмжээ шаардлагатай эсэхийг тодруулна.

3. Ерөнхий зүйл

3.1 Эх булаг ашиглахаар төлөвлөж байгаа болон ашиглагдаж байгаа уст цэгүүдийн байрлаж байгаа орчны ус зүй, ус газар зүй, байршил зүйн зургууд, мэргэжлийн байгууллагуудаас гаргасан дүгнэлт, материалууд

3.2 Усан хагнамжийн багууллага үйлчлэх хүрээний хүн амын тоо, үйлдвэр аж ахуйн газрууд, усан хангамжийн байгуулалтын зураг төсөл (схем)

3.3 Эх булаг хамгаалалтын бүсүүдийг тогтоох боломж, түүний хязгаарууд, хянах зохион байгуулалт

3.4 Эх булгийн усанд усны чанар, найрлагыг тодорхойлох шинжилгээг иж бүрэн үзүүлэлтээр хийсэн дүнгүүд, эрүүл ахуйн дүгнэлт

3.5 Эх булгийн усны чанарыг Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага түүнд тавих хяналт. УСТ 900-92-д заасан хэмжээ хүртэл сайжруулах арга хэмжээ шаардлагатай эсэх, тэдгээрийн технологийн нөхцөл, холбогдох бусад материалууд

3.6 Эх булгаас ус авах байгууламж (цооног, худаг, ус авах төхөөрөмж гэх мэт)-ийн бүтэц, зохион байгуулалт гадны бохирдлоос найдвартай хамгаалагдсан эсэх, тухайн нөхцөлд сайн чанарын ус олдворлож болох эсэх тухай эрүүл ахуйн дүгнэлт

3.7 Ашиглах буюу ашиглагдаж байгаа уст цэг бүрийн ус авах байгууламжуудын техникийн хүчин чадал, хоногт олдворлох усны хэмжээ, усны чанарын тухай материалууд зэргийг тус тус судална.